



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Энх түмэн өрх ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/188/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: <a href="mailto:nandinjargalg@audit.gov.mn">nandinjargalg@audit.gov.mn</a> Санхүүгийн аудитын газрын ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 11315558 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 11315558 Цахим хаяг: <a href="mailto:Altantsetsegya@audit.gov.mn">Altantsetsegya@audit.gov.mn</a> Номч финанс аудит ХХК-ийн захирал: Ц.Эрдэнэбилэг Утас: 88009020 Цахим хаяг: <a href="mailto:nomchfinanceaudit@gmail.com">nomchfinanceaudit@gmail.com</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

НТАГ-2026/188/НА-СТА-ОНӨҮГ

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.13 № 818  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ЭНХ ТҮМЭН ӨРХ ӨЭМТ-ИЙН ДАРГА  
Г.АМАРЖАРГАЛ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Хан-Уул дүүргийн Энх түмэн өрх ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ тусламж, үйлчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан, гүйцэтгэлээр санхүүжилтээ авч ажиллаж байна.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Энх түмэн өрх ӨЭМТ нь 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 955.5 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

### Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, Эрүүл мэндийн ерөнхий газрын санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

1426050885

C:\Users\ranaranga\Desktop\Бичиг хэргэ 2025\2025-03-13\Нийслэлийн бичиг хэргэ 2025

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 59 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны А/156 дугаар тушаалаар 85.4 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 93.7 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
(Төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>Хөрөнгө</b>		
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>47,530,273.32</b>	<b>93,465,278.62</b>
Банкинд байгаа бэлэн мөнгө	1,114,273.32	34,884,615.77
Байгууллагаас авах авлага	46,036,000.00	14,837,207.60
Эм боох материал	-	8,063,943.25
Бичиг хэргийн материал	-	994,300.00
Аж ахуйн материал	380,000.00	29,213,212.00
Бусад хангамжийн материал	-	5,472,000.00
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>5,020,950.00</b>	<b>220,726,778.44</b>
Биет хөрөнгө	5,020,950.00	220,276,778.44
Биет бус хөрөнгө	-	450,000.00
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>5,020,950.00</b>	<b>220,726,778.44</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>52,551,223.32</b>	<b>314,192,057.06</b>
<b>Өр төлбөр</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Бусад өглөг	54,000,000.00	-
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>54,000,000.00</b>	-
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>54,000,000.00</b>	-
<b>Эздийн өмч</b>		
Өмч: - төрийн	20,000.00	20,000.00
Хуримтлагдсан ашиг	(1,468,776.68)	314,172,057.06
Өмнөх үеийн үр дүн	(1,459,856.68)	(1,468,776.68)
Тайлант үеийн үр дүн	(8,920.00)	315,640,833.74
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>(1,448,776.68)</b>	<b>314,192,057.06</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>52,551,223.32</b>	<b>314,192,057.06</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх үе	Тайлант үе
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>5,907,000.00</b>	<b>1,203,532,178.39</b>
Санхүүжилтийн орлого	-	955,475,516.80
Бусад орлого	5,907,000.00	248,056,661.59
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,915,920.00</b>	<b>887,891,344.65</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,507,370.00	648,451,817.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,929,600.00	76,747,379.55
Хангамж, бараа материалын зардал	-	35,210,746.50
Эм, эмнэлгийн хэрэгслийн зардал	-	65,922,650.85
Эд хогшил, урсгал засварын зардал	-	325,200.00

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	592,900.00	33,067,376.53
Бараа үйлчилгээний бусад зардал	886,050.00	28,066,174.22
Бусад урсгал шилжүүлэг	-	100,000.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>(8,920.00)</b>	<b>315,640,833.74</b>
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(8,920.00)</b>	<b>315,640,833.74</b>
Орлогын татварын зардал	-	-
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(8,920.00)</b>	<b>315,640,833.74</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(8,920.00)</b>	<b>315,640,833.74</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-ын хувь оролцооны дүн
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>20,000.00</b>		<b>(1,459,856.68)</b>	<b>(1,439,856.68)</b>
Тайлант үеийн цэвэр (алдагдал)	-		(8,920.00)	(8,920.00)
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>20,000.00</b>		<b>(1,468,776.68)</b>	<b>(1,448,776.68)</b>
Тайлант үеийн үр дүн	-		315,640,833.74	315,640,833.74
<b>2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>20,000.00</b>	-	<b>314,172,057.06</b>	<b>314,192,057.06</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант үе
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	<b>1,001,942,168.03</b>
Санхүүжилтийн орлого	-	940,638,309.20
Бусад орлого	-	61,303,858.83
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>5,463,090.00</b>	<b>948,472,625.58</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,560,590.00	644,762,815.35
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,929,600.00	76,747,381.20
Хангамж, бараа материалын зардал	380,000.00	58,632,702.50
Эм, эмнэлгийн хэрэгслийн зардал	-	72,643,250.00
Эд хогшил, урсгал засварын зардал	-	325,200.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	592,900.00	88,258,476.53
Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,002,800.00
Бусад урсгал шилжүүлэг	-	100,000.00
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(5,463,090.00)</b>	<b>53,469,542.45</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн(+)</b>	-	-

<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн(-)</b>	-	<b>19,699,200.00</b>
Тоног төхөөрөмж худалдаж авсан	-	19,699,200.00
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	<b>(19,699,200.00)</b>
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(5,463,090.00)</b>	<b>33,770,342.45</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>6,577,363.32</b>	<b>1,114,273.32</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,114,273.32</b>	<b>34,884,615.77</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.